

АХУЙН ОСЛЫН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Г.ГАНЧИМЭГ

ДХИС-ийн АШБС-ийн “Гамшиг судлал”-ын магистрант
Ganchimeg_Galtsog@yahoo.com

Хураангуй

Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудлын нэг бол яах аргагүй хүүхэд хамгааллын тухай юм. Энэхүү асуудлын гол цөм нь эцэг эхчүүдийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүн болж төлөвшихдөө олж авсан академик боловсрол билээ. Тэр ч утгаараа цаг хугацааны аль ч үед аав ээжүүдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх талаар нэгдсэн шийдэлд хүрэхийг зорилго болгон өдийг хүрсэн. Гэхдээ энэхүү асуудал нь зөвхөн Монголд ч биш дэлхийн улс орнуудад ус агаар мэт үгүйлэгдэж буй юм. Тэр ч утгаараа энэ асуудалд ихээхэн анхаарч янз бүрээр шийдэж байгаа үй олон туршлага сургамж байна. Энэ хүрээнд ажиглагдаж байгаа нэг нийтлэг зүйл бол эцэг эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, багш сурган хүмүүжүүлэгч, төрийн болон төрийн бус байгууллагууд өөр өөрийн үүрэг хариуцлагатай байж түүнийгээ хэрэгжүүлэх явдал юм.

Хүүхэд хамгаалал гэдэг нь нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц мэргэшсэн үйл ажиллагаа юм. Харин урьдчилан сэргийлэх гэж аливаа үйл явдал, нөхцөл байдлыг бий болгохгүй байхын тулд урьдчилан авч байгаа арга хэмжээг хэлнэ.

Түлхүүр үг: Конвенц, ассамблей, НҮБ, пакт

Оршил

Манай орны хувьд түгээмэл тохиолддог болон тохиолдож болох осол гамшгийн төрлүүд гэвэл объектын болон ой хээрийн түймэр, зам тээврийн осол, хүчтэй цасан болон шороон шуурга, үер, аянга цахилгаан, хүн малын гоц халдварт өвчин, химийн хорт бодис, хий алдагдах, асгарах, тэсрэх дэлбэрэх бодисын аюул, газар хөдлөлт гэх мэт олон гамшиг осол байдаг бөгөөд үүнд олон хүүхэд өртөж амь нас эрүүл мэндээрээ хохирсон судалгаа байна.

Тэсрэлт, дэлбэрэлт, нуралт, аянга цахилгаан, автын осол, газар хөдлөлт гээд ихэнх осол гамшиг нь гал түймрийг бий болгодог. Янз бүрийн үүдэлтэй гал түймрийн аюулаас жилд 450 орчим хүний амь насыг аварч байгаа хэдий ч 50-60 хүн амь насаа алдаж байгаагийн 20-50 орчим хувь нь хүүхэд байна. Тэдгээрийг насаар нь ангилж үзэхэд дийлэнх нь 3-6 насны хүүхэд байгаа бөгөөд энэ нь

“манай хүүхэд том боллоо, юм ойлгодог, ухамсарладаг, биеэ даахтай боллоо” гэж тайвшран гэртээ ганцааранг нь үлдээдэг, хараа хяналтгүй орхидогтой холбоотой болохыг харуулж байна. Объектын гал түймэр гол төлөв нэг дэх, тав дахь, хагас сайнд эсвэл сургуулийн амралт эхлэх үеэр ихэсдэгийг олон жилийн судалгаа харуулж байна.

Гал түймрийн шалтгаан нөхцөлийг судалж үзэхэд хүүхдийн болгоомжгүй үйлдэл, насанд хүрэгчдийн хориглоод байдаг гал түлэх, цахилгаан зуух, лаа, шүдэнз асаах зэргийг туршиж үзэх гэсэн сониуч зангаас үүдэлтэй байх нь олонтой байна. Хүүхдийн болгоомжгүй үйлдлээс болж гарсан гал түймрийг цаг хугацааны хувьд авч үзвэл 11-18 цагийн хооронд гарсан байна. Үүнийг цэцэрлэгийн насны нийт хүүхдийн дөнгөж 40 орчим хувь нь цэцэрлэгт хамрагдаж үлдсэн 60 хувь нь эцэг эхийн хараа хяналт сул, эрсдэлтэй орчинд амьдарч байгаатай холбож үзэхээс өөр аргагүй юм. Түүнээс гадна хүүхдүүд ахуйн осолд нэрвэгдэж гэмтэж бэртэх, амь насаа алдах явдал маш их байна. Үүнд хүүхдийн ахуйн ослоор нас баралтын 21 хувь нь зам тээврийн осол, 16 хувь нь түлэгдэлт, 14 хувь нь усанд живэх, 17 хувь нь хордолт, 32 хувь нь юмнаас унах зэрэг бусад шалтгаантай байна.

Ахуйн түлэгдэлтийн 91.3 хувийг 1-4 насны хүүхэд эзэлж байгаа нь онцгой анхаарал татаж байгаа бөгөөд аав ээжүүд гэр орондоо байхдаа ч бага насны хүүхдүүдийн харж хандахгүй зөнд нь орхидгийг харуулж байна. Осол гарах болсон шалтгааныг судалж үзэхэд 89.3 хувь нь эцэг эхийн хараа хяналт сулаас 10.7 хувь нь анхаарал болгоомжгүй байдлаас болсон байна.

Тухайлбал өнгөрсөн жилийн тоон мэдээллийг бүхэлд нь харахад улсын хэмжээнд 4681 удаагийн аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 202 хүн амь насаа алдсаны 32 буюу 15,8 хувь нь хүүхэд байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 46 хувиар буурсан нь сайшаалтай ч ямар ч үед хүүхэд эндэх учиргүй билээ.

2019 онд аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан 32 хүүхдийн 18 буюу 56.2 хувь нь эрэгтэй, 14 буюу 43.8 хувь нь эмэгтэй байна. Эдгээр амь насаа алдсан хүүхдүүдийн 71.8 хувь буюу 23 хүүхэд хөдөө орон нутагт, 28.2 хувь буюу ес нь Улаанбаатар хотод байна. Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүүхдийн 46.8 хувь буюу 15 хүүхэд объектын гал түймэрт, 31.3 хувь буюу 10 хүүхэд усны ослоор, 6.3 хувь буюу хоёр хүүхэд үерийн улмаас, 15.6 хувь буюу таван хүүхэд бусад осолд өртөж амь насаа алдсан харамсалтай тоон мэдээлэл бий. Энэ дундаас хүүхэд хамгийн их өртдөг, эрсдэл өндөр нь ахуйн гал түймэр. Бага насны хүүхдүүд галаа түлэх гэж оролдох, цахилгааны залгуурын ачааллаас болж объектын гал түймэр их гарч байгаа юм.

2019 онд улсын хэмжээнд объектын гал түймэр нийт 3908 удаа гарч 54 хүн амь насаа алдсанаас 15 хүүхэд түлэгдэж, бэртсэн 68 хүнээс зургаан хүүхэд байна. Гал түймэрт өртөж амь насаа алдсан хүний 27.7 хувь нь бага насны хүүхэд байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүүхэд 48.3 хувиар, түлэгдсэн хүүхэд 57.1 хувиар буурсан үзүүлэлт гарсан. Онцгой байдлын

байгууллагаас бага насны хүүхдүүд объектын гал түймэрт өртөж амь насаа алдаж байгаа шалтгааныг судалж үзэхэд:

- ✓ эцэг эхчүүд бага насны хүүхдүүдийг хараа хяналтгүй үлдээснээс,
- ✓ хүүхдийг цоожилж орхисноос,
- ✓ пийшин зууханд эвдрэл гэмтэл гарснаас,
- ✓ цахилгааны утас, залгуурын бүрэн бүтэн байдал алдагдсанаас,
- ✓ ил гал гарах зүйлс, шатах тослох материалыг хараа хяналтгүй

байлгаснаас гал түймэр гарч хүүхэд өртөх эрсдэл өндөр байгааг тогтоожээ.

Ахуйн гал түймрийн улмаас сүүлийн гурван жилийг харвал:

- ✓ 2017 онд 20 хүүхэд нас барж, 12 хүүхэд түлэгдэж гэмтсэн
- ✓ 2018 онд 33 хүүхэд нас барж, 15 хүүхэд түлэгдэж гэмтсэн

- ✓ 2019 онд 15 хүүхэд нас барж, 6 хүүхэд түлэгдэж гэмтсэн. Усны ослын улмаас:
- ✓ 2017 онд 13 хүүхэд
- ✓ 2018 онд 21 хүүхэд
- ✓ 2019 онд 10 хүүхэд нас барсан байна.

Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын тухай ерөнхий ойлголт

Монгол Улс нь хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлж, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно хэмээн Үндсэн хуулиндаа тунхагласан байдаг билээ. Ийм ч учраас дэлхийн жишигт нийцүүлж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүрээнд баталсан хүний эрхийн олон улсын гэрээ конвенцуудад нэгдэн орсоор байна. Тэдгээрийн нэг 1989 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенц бөгөөд Монгол Улс 1990 онд нэгдэн орж, тус конвенцыг соёрхон баталсан тав дахь улс болж байсан түүхтэй. Тус конвенцод нийт 190 улс нэгдэн орсноор эдүгээ хамгийн олон улс хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн гэрээ конвенцод тооцогдож байна.

Хүүхдүүд нас хүйс, нийгмийн гарал, шашин шүтлэг, хаана, хэнээс төрсөн зэргээсээ үл хамааран эрүүл, аюулгүй, аз жаргалтай бүрэн дүүрэн амьдралаар амьдрах ёстой хэмээх үзэл нь энэхүү конвенцын үндэс болдог. Энэ үүднээс хүүхэд бүр ямар эрх эдлэх ёстой, эдгээр эрхээ эдлэхэд нь эцэг эх, асран хамгаалагч, гэр бүл, төр засаг ямар үүрэг хүлээх ёстой тухай эл конвенцод нарийвчлан заасан байна. Хүүхдийн эрх нь 18 хүртэлх насны хүн бүр эдлэх Хүний эрх юм. Өнөөгийн, хүнлэг энэрэнгүй ёс түгэн дэлгэрсэн, глобалчлагдсан дэлхий ертөнцөд хэн бүхэн эрхэмсэг, үнэ цэнэтэйгээр амьдрахад зайлшгүй шаардлагатай суурь стандарт бол хүний эрх билээ. Хүн бүрд эрх, эрх чөлөө, эрхэмсэг байдал, халдашгүй дархан байдал бий гэж үздэг бөгөөд эдгээр нь хүн болж төрсний маань хувьд та бидэнд заяагдсан төрөлх чанар гэж нэгэнт хүлээн зөвшөөрөгджээ. Хүн ямар эрхтэй болохыг 1948 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас баталсан Хүний эрхийн түгээмэл

тунхаглалд нарийвчлан заасан байдаг. Хүний эрх нь төрөлхийн, салшгүй, түгээмэл, хуваагдашгүй чанартай. Монголчууд бид хүний насыг эхийн хэвлийд олдсон үеэс эхэлж тооцдогтой адил олон улсад хүнийг эхийн хэвлийд бүрэлдсэн цагаасаа эхлэн эрхээ эдлэх ёстой гэж үзэх хандлага байдаг нь энэхүү төрөлхийн чанарын үндэс юм. Хүний эрхийн салшгүй чанар нь эрхийг хүнээс өөрөөс нь салгаж ойлгож болохгүй, түгээмэл чанар нь хүн дэлхийн хаана ч амьдарч байсан эрхээ эдлэх ёстой гэсэн утгыг илэрхийлнэ. Хуваагдашгүй гэдэг бол эдгээр эрхүүд нь нэгэн цогц цөмийг бүрдүүлж, аль нэгийг нь орхиж хаягдуулах боломжгүй харилцан уялдаатай, нэг эрх нь зөрчигдөхөд бусад нь зөрчигдөх үндэс суурь болж байдаг гэсэн үг юм. Хүний эрх нь зөвхөн нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг. Энэ нь бусдын эрхийг зөрчихгүй л бол Та бид юу ч хийж болох эрх чөлөөтэй гэсэн үг юм. Энэ бүх чанар хүүхдийн эрхэд байдаг.

Хүүхдийн эрх, түүний үндсэн зарчим, ач холбогдол

Хүүхдийн эрхийн үндсэн зарчим бол хүүхдийн язгуур эрх ашгийг эн тэргүүнд тавих явдал. Хүүхдийн нөхцөл байдал, хэрэгцээг бүрэн дүүрэн судалж, хүсэл сонирхол, үзэл бодлыг нь харгалзан үзсэний үндсэн дээр түүний эрүүл мэнд, хөгжил, хамгаалал, одоо болон ирээдүйн сайн сайхны төлөө хамгийн зөв шийдвэрийг гаргахтай энэ нь холбоотой.

Мөн тодорхой нөхцөлүүдэд хүүхдийн эрх ашиг нь эцэг эх, бусад холбогдох насанд хүрэгчдийн эрх ашгаас дээгүүр тавигдана гэсэн үг.

Хууль тогтоох, шүүх, захиргаа, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн бүхий л байгууллага хүүхэдтэй холбоотой шийдвэртээ энэхүү язгуур эрх ашгийн зарчмыг ягштал баримтлах нь Хүүхдийн эрхийн конвенцын үндсэн шаардлага юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенцод нийт 4 үндсэн зарчим байдгийн нэг дэх нь энэхүү язгуур эрх ашгийн зарчим бөгөөд хоёр дахь нь хүүхдийн амьдрах, хөгжих эрхийн зарчим, гурав дахь нь хүүхдийг үл ялгаварлах зарчим, дөрөв дэх нь хүүхдийг үзэл бодлыг нь хүндэтгэх, эрх ашигт нь нөлөөлөх асуудлаар шийдвэр гаргахад оролцуулах зарчим юм.

Хүүхэд бол насанд хүрэгчидтэй харьцуулахад чадавхын хувьд өөр, өсөж хөгжиж, төлөвших шатандаа яваа хүн юм. Ийм ч учраас хүүхэд онцгойлон асрамжлуулж хамгаалуулах эрхтэй тухай Хүний эрхийн түгээмэл тунхаглалд дурдсан байдаг. Хүүхдийн эдлэх ёстой эрх нь Хүүхдийн эрхийн конвенцод дараах байдлаар заагджээ. Үүнд:

- ✓ Хүүхэд амьдрах эрхтэй
- ✓ Хүүхэд төрмөгцөө бүртгүүлэх, нэр авах, иргэний харъяалалтай болох эрхтэй
- ✓ Хүүхэд эцэг эхээ мэдэх, хайр халамжийг нь хүртэх эрхтэй
- ✓ Эцэг эхээсээ салж хагацсан бол язгуур эрх ашигт нь харшлахаас бусад үед тэдэнтэйгээ байнга хувийн, шууд харилцаа холбоотой байх эрхтэй
- ✓ Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй
- ✓ Хүүхэд мэдээлэл авах эрхтэй
- ✓ Хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, сүсэглэх эрхтэй
- ✓ Хүүхдүүд эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран цуглах эрхтэй
- ✓ Өөрийн эцэг эх, асран хамгаалагч болон бусад хүний зүгээс бие махбод, сэтгэл зүйн хувьд дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бус, хэрцгийгээр хандах, албадан хөдөлмөрлүүлэх, худалдаалах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх явдлаас хамгаалуулах эрхтэй
- ✓ Хүүхэд хууль ёсны дагуу үрчлэгдэх эрхтэй
- ✓ Хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй бол онцгой халамж, анхааралд байх эрхтэй
- ✓ Хүүхэд эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй
- ✓ Хүүхэд нийгмийн халамж хүртэх эрхтэй
- ✓ Хүүхэд бүх төрлийн боловсрол эзэмших эрхтэй
- ✓ Хүүхэд оюуны, бие махбодын, ёс зүйн болон нийгмийн хөгжлийг нь хангахуйц амьжиргаатай байх эрхтэй
- ✓ Хүүхэд амрах, тоглох, чөлөөт цагаа зүй зохистой өнгөрүүлэх эрхтэй.

Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хүүхэд нийгэм, улс төр, соёл, эдийн засаг, иргэний эрхүүдтэй болохыг ийнхүү тунхагласан. Эдгээрийг амьдрах, хөгжих, оролцох, хамгаалуулах гэсэн дөрвөн багц эрхэд ч хувааж болно.

Хүний эрх, хүүхдийн эрхийн тухай ойлголтод нэг талаас эрх эдлэгч, нөгөө талаас үүрэг хүлээгч гэж байдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн заажээ.

Эрх эдлэгч нь хүүхэд байх үед нэг дэх үүрэг хүлээгч нь төр, хоёрдогч үүрэг хүлээгч нь эцэг эх, асран хамгаалагч байна. Төр засаг хүүхдийн өмнө эрхийг нь (1) хүндэтгэх, (2) хамгаалах (3) хангах үүргийг хүлээдэг. Хүүхдийн эрхийг хүндэтгэх гэдэг нь төр засаг буюу түүний үүргийг биелүүлж буй аливаа төрийн албан хаагчид (тухайлбал багш, эмч, цагдаа, төрийн яамд, агентлаг болон орон нутгийн засаг захиргааны ажилтнууд) хүүхдийн эрхийг зөрчихгүй, эрхээ эдлэх явцад нь ямар нэг саад учруулахгүй байх гэсэн үг юм. Хүүхдийн эрхийг төрөөс хамгаалах гэдэг нь өөр бусад этгээд байгууллага, бүлгийн зүгээс хүүхдийн эрхийг зөрчих, эрхээ эдлэх явцад нь саад учруулахаар бол урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариуцлага тооцох ёстой гэсэн ойлголт юм.

Хүүхдийн эрхийг төрөөс хангах гэдэг нь хүүхэд эрхээ эдлэхэд шаардлагатай нөхцөл бололцоог бүрэн бүрдүүлэх асуудал юм. Жишээ дурдвал, хүүхэд хөгжих боловсрох эрхтэй учраас төр сургууль байгуулж, хэрэгцээтэй тавилга, тоног төхөөрөмж, хэрэгслээр хангаж, багш нарыг бэлдэн, цалинжуулж, ажлыг нь хянаж, боловсролын орчныг хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй байхад анхаардаг.

Хүүхдийн эрхийн конвенцын хүрээнд гишүүн улсууд хүүхдийн дээр дурдсан эрхүүдээ эдлэх боломж бололцоог бүрэн бүрдүүлэхийн сацуу дараах онцлог үүргийг хүлээдэг:

- ❖ Хүүхэд эцэг эхтэйгээ, эцэг эх хүүхэдтэйгээ эргэн нэгдэх зорилгоор гишүүн улсын нутаг дэвсгэрт нэвтрэх, гарах явдлыг зөвшөөрнө.

- ❖ Эцэг эх хүүхдэдээ хэрцгийгээр хандах, анхаарал халамжгүй орхих, тусдаа амьдрах болсноос бусад үед хүүхдийг хүсэл зоригийнх нь эсрэг эцэг эхээс нь салгахгүй. Хүүхдийг эцэг эхээс нь зөвхөн язгуур эрх ашгийг нь хангахын төлөө эрх бүхий байгууллага мөрдөгдөж буй хууль журмыг үндэслэн гаргасан шүүхийн шийдвэрийн дагуу салгаж болно. Энэ тохиолдолд түүний сайн сайхан байдлыг хангах тогтвортой арга хэмжээг заавал авна.

- ❖ Эцэг эхгүй хүүхдийн халамж хамгааллын асуудлыг үрчлэлт зэрэг хувилбарт хэлбэрүүдийн хүрээнд шийднэ. Үүнд гэр бүлд түшиглэсэн халамжийн хувилбаруудыг нэн тэргүүнд авч үзнэ

- ❖ Баривчлагдаж саатуулагдсан, хоригдсон хүүхдийг насанд хүрэгчдээс салгаж байрлуулах ёстой бөгөөд түүнийг тамлан зовоох, доромжлох, харгис хэрцгийгээр харьцахыг хориглоно.

- ❖ Хүчирхийлэл, үл хайхрал, мөлжлөг зэрэг зүй бус харьцааны улмаас хохирсон хүүхдийг зохих ёсны эмчилгээ, нөхөн сэргээх үйл ажиллагаанд хамруулна.

- ❖ Гишүүн улсууд Конвенцын үзэл баримтлал, зүйл заалтын тухай хүүхэд, насанд хүрэгчдэд таниулах үүднээс энэ тухай мэдээллийг өргөнөөр түгээн дэлгэрүүлнэ.

Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдэд эрүүл энх өсөн торних, боловсрол эзэмших, бие хүний хувьд хүмүүжин төлөвших, нийгмийн болон гэр бүлийн харилцаанд суралцах, бие даан амьдрах чадвар эзэмшихэд нь дэмжлэг үзүүлж, хөгжлийн зайлшгүй хэрэгцээг нь хангаж байдаг. Үүнд орон байр, хоол хүнс, хувцас хунар гэх мэт хүүхдийн үндсэн хэрэгцээнээс гадна аюулгүй тайван орчин бүрдүүлэх, хайр халамж халуун дулаан сэтгэл, урам зоригээр тэтгэх, болох болохгүйн зааг ялгааг заан сургаж бие даасан амьдралд бэлтгэх зэрэг орно. Ийнхүү хүүхдийн хөгжил хүмүүжлийн асуудалд эцэг эх, асран хамгаалагч гол хариуцлагыг хүлээдэг ба төр эцэг эхэд энэхүү үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай тусламж дэмжлэгийг үзүүлэх үүрэгтэй.

Дүгнэлт

Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлтэй нөхцөл байдалд орохгүй байх үүднээс аав ээжүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид, нийт насанд хүрэгчид хүүхэд хамгааллын арга хэмжээг байнга авч байх ёстой. Үүний тулд эдгээр хүмүүс хүүхэд хамгаалал, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх талаар мэдлэгтэй, чадвартай, дадал зуршилтай болсон байх шаардлагын үүднээс БСШУСЯ, ОБЕГ, ГБХЗХГ хамтран хүүхэд, аав ээж, асран хамгаалагч, багш

сурган хүмүүжүүлэгч, аврагчдад зориулсан сургалтын хөтөлбөр төлөвлөгөөнүүдийг гаргаж хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал, эх үүсвэрийн жагсаалт

1. Үржин О., Санжаабадам С., Цэцэгмаа Б. Аюулгүй амьдрах ухаан I УБ.: 2011.
2. Үржин О., Санжаабадам С., Цэцэгмаа Б. Аюулгүй амьдрах ухаан I УБ.: 2011.
3. Чинзориг С. Амьдралын төлөө тэмцэл УБ. 2008
4. Энхтуяа С., Эрдэнэчимэг Б., Энхжаргал Д. Гэр бүлд түшиглэсэн хүүхдийн халамжийн хувилбарт үйлчилгээ УБ 2010
5. Батхишиг А., Энхтуяа С. Хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нь УБ.: 2011, Хүүхдийг Ивээх Сан
6. Энхтуяа С. Хүүхэд хамгааллын үндэс УБ. 2009 Хүүхдийг Ивээх Сан